



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Ц.БАТБАЯР ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.09.04 № 568

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Ц.Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

.. 011021663

## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч 213191910465 иргэний бүртгэлийн дугаартай Цэрэнжав овогтой Батбаярын аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Ц.Батбаярын мөрийн хөтөлбөр 2 хуудас хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч "Ц.Батбаяр"-т

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын

2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч

Цэрэнжавын Батбаярын 2024-2028 онд хийж, хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр

1. Санхүү, эдийн засгийн хөгжил

- Орон нутгийн төсвийг бодитой төлөвлөж, төсвийн орлогын үр өгөөжийг тухайн ондоо бүрэн ашиглах, нөгөө талаар бодит хөрөнгө оруулалтыг тусгаж аж ахуй нэгжүүдэд хүлээлт үүсгэхгүй
- Сум орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжинэ. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн бодит байдлаар хэмжиж, хяналт тавьж ажиллана.
- Хувийн хэвшлийн бизнес, хөрөнгө оруулалтыг орон нутагт татахад сөргөөр нөлөөлж байгаа асуудлууд болон төрийн хүнд суртал ойлгомжгүй байдлыг хална.
- Зүүн хойд азийн дэд бүтцийн хөгжилд нэгдэж эдийн засгийн хувьд идэвхитэй хот болоход анхаарч ажиллана.
- Боомтын сэргэлтийн хүрээнд хөрш зэргэлдээ улсуудтай худалдаа, хил орчмын аялал жуучлалыг хөгжүүлэх, энэ чиглэлээр онцгой бүтээгдэхүүнүүдтэй болох
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад нээлттэй аймаг болно.

2. Уул уурхай

- Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэдтэй шууд хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх,
- Иргэд, орон нутгийн удирдлага, уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагуудыг энэ чиглэлээр хамтран санаачлагатай ажиллахад дэмжих
- Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн захиргааны байгууллагуудтай байгуулсан гэрээний дүнгийн тодорхой хувийн гүйцэтгэлээр тайлагнадаг болгох
- Засгийн газрын тогтоолоор Стратегийн байж болохуйц гэх зарим орд газруудын тодорхой хувийг орон нутгийн болон төрийн мэдэлд хувь эзэмших асуудалд иргэдээр хэлэлцүүлэх, санаа бодлыг тусгах
- Уул уурхайн салбарын ханган нийлүүлтэнд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд хяналт тавьж ажиллах,
- Уул уурхайн хагас боловсруулах үйлдвэрүүдийг аймагтаа байгуулахыг дэмжиж ажиллана

3. Байгаль орчин Ногоон хөгжил

- Амьдрах орчины ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд төсвийн болон хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэх бодлого баримтлах
- Хэрлэн голын ногоон бүсэд олон нийтийн гүйлтийн стандарт талбай, хөлбөмбөгийн талбай байгуулахад төсөл хөтөлбөр, нийгмийн хариуцлагын хүрээнд иргэн аж ахуй нэгжээс хөрөнгө оруулалтыг татах
- Ерөнхийлөгчийн "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлнэ
- Тухайн бүс нутгийн ургамал, амьтан, байгалийн баялагийг тухайн бүс нутагтаа зүй зохистой ашиглахад санаачлага гарган ажиллана.

4. Хог

- Орон нутгийн онцлогт нийцсэн Аймаг сумын хамтарсан хогны менежментийг боловсруулж хэрэгжүүлэх

- Аймаг, сумын төсвийн хөрөнгөөр хог тээвэрлэх, хог боловсруулах урсгал үйл ажиллагааг хувийн хэвшлүүдтэй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх
  - Хог ангилан ялгах асуудалд бодитоор хандах, залуу хойч үедээ уг асуудлаар дадал зуршил болгоход анхаарах
  - Аймгийн төвд хог хаях, ил задгай нийтийн эзэмшилд элс, хайрга барилгын материал буулгахыг хориглох, арга хэмжээ авах
  - Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Аюултай хог хаягдлын талаар дүгнэлт гаргуулах, хариу арга хэмжээг авах
5. Зам
- Орон нутгийн зорчих зам, хот доторх авто замын талаар бодлого гаргах.
  - Хот доторх автозамын тоосжилт, бохирдолтыг зогсооход механик байдлаар бүрэн цэгцлэх, илүүдэл шавар шороог хотоос гаргах
  - Сум орон нутгийн зорчих замуудыг эзэнжүүлж, урсгал засвар болон засвар үйлчилгээг зун өвлийн цагт тогтмол хийлгэх.
  - Хот доторх түүхий нүүрс тээврийн замыг шинэчлэх ажлыг бэлтгэн нийлүүлэгч болон худалдан авагч талуудаас шаардана.
  - Хот доторх нүүрс элс шороо гэх мэт хүнд бохирдолтой тээврүүдийн стандартыг бариулна.
6. Нийгмийн баталгаа
- Үйлчилгээний салбарт шинэ өнгө төрх, цэмцгэр байдлыг илэрхийлсэн иргэд аж ахуй нэгжүүдийг алдаршуулах, хөгжүүлэхэд дэмжлэг болж ажиллана.
  - Ахмадын ажил хөдөлмөр эрхлэх, нийгэмд үлгэр жишээ байдлыг хэвшүүлэхэд ахмадын хөтөлбөрүүдээр дэмжлэг үзүүлэн ажиллах
  - Залуу малчин, иргэдийг нийгмийн баталгаагаар хангахад "Малчин нийгэм" хөтөлбөр боловсруулан ажиллана.
  - Хүүхэд залуучуудын тоглох, хөгжих орчныг нас насны онцлогоор тэнцвэртэй байгуулах, шинэ орчин, шинэлэг талбайнуудыг төрөлжүүлэн бүтээн байгуулах
7. Эрүүл мэндийн чиглэлээр
- Эрүүл мэндийг тусламж үйлчилгээний чанрыг сайжруулах
  - Эмч эмнэлэгийн ажилчдын ур чадварыг сайжруулахад анхаарах
  - Тэргүүлэх чиглэлийн өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлээр тасаг нэгжүүдийг нэмэгдүүлж, орон нутагаа эмчилгээ үйлчилгээг авахад анхаарах
8. Боловсролын хөгжил
- Төрөөс баримтлаж буй боловсролын бодлогыг орон нутагт чанартай хэрэгжүүлэх
  - Гадаад улсын их дээд сургуульд горьлогчдыг нэмэгдүүлэх

